

БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ

2023 оны 11 сарын 28 өдөр

СУУРЬ БҮТЭЦ ХООРОНД СОЛИЛЦОХ, ДАМЖИН ӨНГӨРӨХ АЧААНЫ ХЭМЖЭЭ ТОХИРОЛЦОХ ЗӨВЛӨГӨӨНИЙ УДИРДАМЖ

Нэг.Зөвлөгөөний зорилго

Суурь бүтэц хооронд солилцох, дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох ээлжит зөвлөгөөний зорилго нь төмөр замын дотоодын сүлжээний суурь бүтцүүдээр 2024 онд дамжин өнгөрөх ачааны хэмжээг тохиролцох, ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оршино.

Хоёр.Хугацаа, зохион байгуулагдах газар

Зөвлөгөөн 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08:00-17:00 цагт зохион байгуулагдана.

Гурав. Зохион байгуулагч байгууллага

Зохион байгуулагч: “Монголын төмөр зам” ТӨХК;
Хамтран зохион байгуулагч: “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ.

Дөрөв.Зөвлөгөөнд оролцогч байгууллага

1. Зам, тээврийн хөгжлийн яам;
2. “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ;
3. “Улаанбаатар төмөр зам” ХНН;
4. “Монголын төмөр зам” ТӨХК;
5. “Тавантолгой төмөр зам” ХХК;
6. “Монголиан транс лайн” ХХК, “Монголиантранс ложистик” ХХК.

Тав.Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлууд

1. Суурь бүтцүүдээр 2024 онд дамжуулан тээвэрлэх ачааны хэмжээг тохиролцох;
2. Галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтын талаар;
3. Ачаа тээврийн ажлын зохион байгуулалтын талаар;
4. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын талаар;
5. Бусад асуудал (тариф, төлбөр тооцоо, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар).

Зургаа. Дараагийн ээлжит зөвлөгөөн зохион байгуулах хугацаа, хариуцан зохион байгуулагчийг тохиролцох

6. Зөвлөгөөнийг “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын захирал (А.Буяннэмэх) удирдана.
- 6.1. Зөвлөгөөний бүрэлдэхүүнд суурь бүтцүүдийн эрх бүхий удирдах албан тушаалтан, холбогдох мэргэжилтнүүд оролцоно.
- 6.2. Зөвлөгөөн зохион байгуулахад Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/37 дугаар тушаалаар баталсан “Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ыг баримтална.
- 6.3. Суурь бүтцүүдийн хооронд тээвэрлэх ачааны хэмжээг хөрш орнуудын хилийн төмөр замуудтай солилцох тээврийн хүчин чадалд нийцүүлэн тохиролцоно.
- 6.4. Зөвлөгөөнөөр асуудлыг хэлэлцэхэд холбогдох суурь бүтцүүдээр бүлэгт хуваана.
- 6.5. Бүлгийн дарга тухайн суурь бүтцүүдийн харилцсан солилцсон саналуудыг урьдчилан нэгтгэж, хэлэлцүүлгийн бэлтгэл хангасан байна.
- 6.6. Зөвлөгөөнөөр асуудлыг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.7. Зөвлөгөөний протоколд зөвлөгөөний даргалагч болон эрх бүхий суурь бүтцүүдийн төлөөлөгчдийн тэргүүн гарын үсэг зурж баталгаажуулна.
- 6.8. Суурь бүтцүүдийн төлөөлөгчдийн тэргүүн гарын үсэг зурах итгэмжлэлтэй байна.

Долоо. Зөвлөгөөний бэлтгэл

Зөвлөгөөн зохион байгуулагч нь зөвлөгөөн зохион байгуулахаас өмнө зөвлөгөөнөөр асуудлыг хэлэлцэх холбогдох суурь бүтцүүдийг бүлэгт хуваасан байна.

Зөвлөгөөн зохион байгуулагч нь бүлгүүдийн дарга нараас суурь бүтцүүдийн харилцан солилцсон саналуудыг урьдчилан нэгтгэж, зөвлөгөөний бэлтгэл хангасан байна.

Найм. Зөвлөгөөний хөтөлбөр

д/д	Арга хэмжээ	Хугацаа
1	Зөвлөгөөний бүртгэл	07:40 – 08:00
2	Зөвлөгөөний нээлт ЗТХЯ,Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Итгэлт	08:00 – 08:05
3	Хурлын дэг танилцуулга, зохион байгуулалт “ГТХЗНТ” УТҮГ-ын захирал А.Буяннэмэх	08:05 – 08:10
4	Өмнөх хурлын протоколын биелэлтийг танилцуулах “ГТХЗНТ” УТҮГ-ын ЗШМ Ж.Алимаа	08:10 - 08:20
5	I бүлэг. Галт тэрэг, вагон солилцоо, ачааны хэмжээ “УБТЗ” ХНН ахлах “МТЗ” ТӨХК – “МТЛож” ХХК – “УБТЗ” ХНН /Төмөртэй – Хандгайт-Ерөө/	08:20 – 09:10
6	Асуулт хариулт	09:10 – 09:30
6	Цайны завсарлага	09:30 – 09:45
7	II бүлэг. Галт тэрэг, вагон солилцоо, ачааны хэмжээ “МТЗ” ТӨХК ахлах “ТТЗ” ХХК - “МТЗ” ТӨХК – “УБТЗ” ХНН /Тавантолгой-Цогтцэций – Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт, Суурь бүтэц ашиглалт/	09:45 – 10:15
8	Асуулт хариулт	10:15 – 10:30
9	III бүлэг. Галт тэрэг, вагон солилцоо, ачааны хэмжээ “МТЛайн” ХХК ахлах “ТТЗ” ХХК – “МТЗ” ТӨХК – “МТЛайн” ХХК /Тавантолгой-Цогтцэций-Номгон, суурь бүтэц ашиглалт/	10:30 – 11:30
10	Асуулт хариулт	11:30 – 11:50
11	Галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт	11:50 – 12:20
12	Асуулт хариулт	12:20 – 12:40
13	Ачаа тээврийн ажлын зохион байгуулалт	12:40 – 13:10
14	Асуулт хариулт	13:10 – 13:30
15	Цайны завсарлага	13:30 – 14:00
16	Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт	14:00 – 14:30
17	Асуулт хариулт	14:30 – 14:50
18	Бусад асуудал (Тариф, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар)	14:50 – 15:20
19	Асуулт хариулт	15:20 – 15:40
20	Төмөр замын тээвэрлэлтийн нэгдсэн технологийн горимын төслийг танилцуулах ГТХЗНТ УТҮГ	15:40 – 16:00
21	Дараагийн зөвлөгөөнийг аль суурь бүтэц зохион байгуулах талаар зөвшилцөх	16:00 – 16:10
22	Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөнөөс гарсан санал, шийдвэр танилцуулах	16:10 – 16:45
23	Зөвлөгөөнөөс гарсан хурлын протоколд гарын үсэг зурж баталгаажуулах	16:45 – 17:00